



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/140

Арвайхээр

**Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож, бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хуульд заасан эрх хэмжээний дагуу сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдийн албан тушаалын чиг үүргийг тодорхойлон, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Л.Энхбат), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Долгормаа) нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга /Л.Энхбат/-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Хархорин сумын Засаг даргын Тамгын газар, хотын захирагчийн албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн а/491 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

0111003 3

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн АИИГ дугаар захирамжийн хавсралт



ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1.	Засаг дарга	1
2.	Засаг даргын орлогч	1
3.	Тамгын газрын дарга	1
4.	Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	1
5.	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
6.	Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
7.	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	1
8.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
9.	Гэр бүл, хүүхэд, залуучууд, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	1
10.	Хүнс, газар тариалан, хоршоо, экстэйншн, үйлчилгээний салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн	1
11.	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, малын үржил бүртгэл, бэлчээр, тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
12.	Жижиг, дунд үйлдвэрлэл, сум хөгжүүлэх сан, үндсэн чиглэл, төсөл, хөтөлбөр, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	1
13.	Соёл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	1
14.	Угтах үйлчилгээний ажилтан	1
15.	Нягтлан бодогч	1
16.	Багийн Засаг дарга	8
17.	Багийн зохион байгуулагч	3
18.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
19.	Нярав	1
20.	Үйлчлэгч	1
21.	Жолооч	1
Бүгд		30